



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### I ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын I хурал 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 16.30 цагт Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын өрөөнд 80 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид шийдвэрлүүлэх тулгамдсан асуудлын талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэлийн мэдээллийг сонсов.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэлд:

1.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн хангаж, шаардлагатай тохиолдолд резидент эмч нарыг бэлэн байдалд байлгахыг;

1.2. Иргэд, олон нийтэд хандсан цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг нэг цэгээс, бодитой, хүртээмжтэй хүргэх;

Хоёр. Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын сайд Ё.Баатарбилэгт:

2.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл түр хаахыг;

2.2. Тогтоосон хугацаанд суралцагчдад сургалтын хөтөлбөрийн дагуу мэдлэг олгох ажлыг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авахыг;

Гурав. Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт:

3.1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахад шаардагдах санхүүжилтын асуудлыг шуурхай шийдвэрлэхийг;

Дөрөв. Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгаланд:

4.1. Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас гаргасан зөвлөмжийн дагуу нийтийн тээврийн хэрэгслийн эрүүл ахуй, халдвар судлалын нөхцөлийг сайжруулж, хөлбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг;

Тав. Аймаг, нийслэлийн Засаг дарга,  
Онцгой комиссын дарга нарт:

5.1. Олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулахыг түр хугацаагаар хязгаарлахыг;

Зургаа. Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,  
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн,  
бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт:

6.1. БНХАУ-тай хиллэдэг хилийн боомтуудаар зорчигч тээврийн хэрэгслээр болон явганаар зорчих иргэдийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран судлаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлүүлэхийг;


Долоо. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүүд:

7.1. Хилийн хяналтыг сайжруулж, тандалт судалгааг эрчимжүүлж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг;

Найм. Засгийн газрын Хэвлэл мэдээлэл,  
олон нийттэй харилцах хэлтсийн дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганзоригт:

8.1. Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас гаргасан зөвлөмжийн дагуу иргэдэд чиглэсэн эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан шуурхай нийтэлж, нэвтрүүлэхийг тус тус үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### II ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын II хурал 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 15.00 цагт Төрийн ордон дахь Нутгийн удирдлагын танхимд 86 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Улсын онцгой комиссын орлогч дарга, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл;
2. Гадаад харилцааны яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Даваасүрэн;
3. Зам, тээврийн хөгжлийн яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан;
4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг;
5. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулж буй арга хэмжээний талаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү;
6. Хил хамгаалах ерөнхий газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн;
7. Нийслэлийн Онцгой комиссоос авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн С.Амарсайхан нарын мэдээллийг сонсов.

Нэмэлтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ж.Сауле, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Б.Батхишиг, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах албаны дарга цагдаагийн хурандаа Ж.Амгалан нар мэдээлэл хийв.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд:

1.1. Улсын онцгой комиссыг нөхцөл байдлын мэдээллээр тухай бүр хангаж, цаашид мэдээлэл солилцоходоо уялдаа холбоотой ажиллахыг;

1.2. Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайланг Улсын онцгой комисст ирүүлэхийг;

1.3. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хилийн боомт, хорио цээрийн бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа онцгой байдал, хил хамгаалах, цагдаа, мэргэжлийн хяналт, гаалийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг нэг удаагийн хувцас хэрэглэл, эм, бэлдмэлээр хангахад шаардагдах хөрөнгийн асуудлыг нэгтгэн, Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхийг;

1.4. Эмнэлгүүдийн бэлэн байдлыг хангуулж, эмч, мэргэжилтнүүд, резидент эмч нарыг дайчлан ажиллуулахыг;

1.5. Хүн амыг коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллийг хүргэх асуудалд онцгой анхаарч ажиллахыг;

1.6. Голомтын бүсээс ирсэн өвчний шинж тэмдэг илэрсэн иргэдийг тусгаарлах тусгайлан бэлтгэсэн байр бэлтгэх, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авахыг;

Хоёр. Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт:

2.1. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийн асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэж ажиллахыг;

Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгаланд:

3.1. Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас гаргасан зөвлөмжийн дагуу нийтийн тээврийн хэрэгслийн эрүүл ахуй, халдвар судлалын нөхцөлийг сайжруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг;

3.2. Хилийн чанадад байгаа иргэдийг авчрах, дотоодын зорчигч тээврийн хөдөлгөөн зохицуулалтыг тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулахыг;

Дөрөв. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн,  
сайд Ч.Улаанд:

4.1. Хүнсний барааны хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллахыг;

Тав. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Ц.Даваасүрэнд:

5.1. Коронавирусийн халдварын тохиолдол бүртгэгдсэн улс орнуудад оршин суугаа монгол иргэдэд урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг тогтмол хүргүүлж байхыг;

Зургаа. Аймаг, нийслэлийн Засаг дарга,  
Онцгой комиссын дарга нарт:

6.1. Уламжлалт сар шинийн баярыг зөвхөн гэр бүлийн хүрээнд тэмдэглэж, золгол хийхээр олноороо хол зорчихгүй байх, төрийн золголт хийхгүй байх, бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд, нутгийн зөвлөл, хамт олны зохион байгуулалттай золголт хийхгүй байх талаар холбогдох арга хэмжээг авахыг;

6.2. Цагаан сарын хүчит бөхийн барилдаан, морин уралдааныг зохион байгуулахгүй байхыг;

Долоо. Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
хошууч генерал Т.Бадралд:

7.1. Шинэ коронавирусийн халдвараас хүн амыг урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж, мэдээ, тайланг Улсын онцгой комисст нэг цэгт төвлөрүүлж, шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж Засгийн газарт тухай бүр танилцуулж, шийдвэрлүүлэх эрх бүхий Улсын онцгой комиссын шуурхай Ажлын хэсгийг байгуулж ажиллахыг;

Найм. Зэвсэгт хүчний жанжин штабын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн,  
хошууч генерал Д.Ганзоригт:

8.1. Цэргийн албан хаагчдын төлөвлөгөөт бэлтгэл, сургалтыг тухайн анги, салбарын байрлалд зохион байгуулахыг;

Ес. Хил хамгаалах ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн,  
бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт:

9.1. БНХАУ-тай хиллэдэг хилийн боомтуудаар зорчигч тээврийн хэрэгслээр болон явганаар зорчих иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллах, хилээр орж, гарч байгаа зорчигчдоос асуумж судалгааг нарийвчлан авахыг;


9.2. Коронавирусийн халдвар бүртгэгдсэн голомтын бүс нутгаас хүнсний бараа бүтээгдэхүүнийг хилээр оруулахгүй байхад анхаарч, гарал үүслийн бичиг баримтыг сайтар шалгаж, хяналт тавьж ажиллахыг;

Арав. Харилцаа, холбоо,  
мэдээллийн технологийн газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Чинбатад:

10.1. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмжийг үүрэн холбооны оператор компаниудтай хамтран гар утсаар багц мессежээр тухай бүр зохион байгуулахыг тус тус үүрэг болгов.

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД



НЭНХБОЛД